



БАТЛАВ.



Я.АМАРЖАРГАЛ



ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 67

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Монхимо ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь "Гар ариутгагч бодис" худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 8.800.000 (найман сая найман зуун мянга) –н төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн төндөрийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Д/Д	Барааны нэр, төрөл	Багц ийн дугаа	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Санитол гар ариутгагч гель – 300мл	28	Монхимо эмийн үйлдвэр, Монгол улс	фл	1000	8:800	8.800.000

- 1 Захиалагч нь барааны нийлүүлэлтийн 8.800.000 (найман сая найман зуун мянга)-н төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 2 Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 3 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зэрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 4 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлберийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 5 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 6 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаа	Урьдчилгаа /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/
1	Санитол гар ариутгагч гель – 300мл	28		
	Нийт дун			

Хөөр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)

ГЕН 30

Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХЭСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хургэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
..... Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
..... Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
..... Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
..... Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан
Бодогч
..... Х.Ариунтуяа

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн
Мэргэжилтэн
..... Д.Мөнхцэцэг

14210 Улаанбаатар хот Сүхбаатар
ðүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын
VIII байр

Утас: 263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Монхимо ХХК-ийн
Борлуулалтын менежер
..... А.Мөнхзул

Хаяг: Тээвэрчдийн гудамж
АОС№2 Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар
Утас: 11-315664, 88018936

Регистрийн дугаар: 2559994
Банк: Худалдаа хөгжлийн банк
Дансны дугаар: 499001584